

## ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2019.03.18

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Гадаад харилцааны яам /ГХЯ/-ны 2018 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан гаргаж яамны удирдлагад танилцуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж байна.

Тайланд гадаад харилцааны салбарт холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2018 оны жилийн эцсийн биелэлт, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд гадаад бодлого, гадаад харилцаа, хамтын ажиллагааны талаар тусгагдсан зорилт, арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийн явц, байдлыг гаргаж, биелэлтийн хувь, үнэлгээг тусгав.

Дээр дурдсан журмын 9.1.1-д заасны дагуу Гадаад харилцааны яамны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт /Хавсралт-1/, Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт /Хавсралт-2/, Байгууллагын ил тод байдлын үнэлгээний тайлан /Хавсралт-3/, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ /Хавсралт-4/, Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт /Хавсралт-5/, Хэрэглэгчийн үнэлгээний тайлан /Хавсралт-6/, мөн журмын 7 дугаар хавсралтын дагуу ГХЯ-ны жилийн үйл ажиллагааны үнэлгээний дүнг /Хавсралт-7/ тус тус гарган хүргүүлэв.

### **Нэг. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ**

#### **1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт**

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын 6 дугаар хавсралтын дагуу Гадаад харилцааны салбарт холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт, хэрэгжилтийн явцыг 2018 оны байдлаар нэгтгэн журамд заасан хугацаанд 2019 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 13/223 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

2018 оны байдлаар Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем ([www.unelgee.gov.mn](http://www.unelgee.gov.mn))-д Гадаад харилцааны салбарт холбогдох Монгол Улсын хууль, Улсын Их Хурал /УИХ/-ын тогтоол, УИХ-ын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл /ҮАБЗ/-ийн зөвлөмж, ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл,

Засгийн газрын албан даалгавар зэрэг хяналтад авсан нийт 10 төрлийн 224 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 324 зүйл, заалтыг хяналтад авсан байна.

Мөн УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хорооноос /АБГББХ/ 2011 оноос хойш гадаад бодлогын чиглэлээр гаргасан 5 тогтоолын 28 заалтын нарийвчилсан биелэлтийг 2018 онд 2 удаа гаргаж АБГББХ-нд хүргүүлэв.

2018 оны байдлаар хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нийт 324 зүйл заалтаас 218 заалт 100 хувь, 88 заалт 70 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн буюу үнэлгээ өгөх боломжгүй болон хугацаа болоогүй 19 заалт байна.

Хэрэгжилтийн дундаж үзүүлэлт нь **91.37 хувийн** гүйцэтгэлтэй гарсан.

Эдгээрээс бүрэн хэрэгжиж дууссан, хэрэгжих хугацаа нь дуусч цаашид хэрэгжүүлэх боломжгүй болсон, цаг хугацааны хувьд ач холбогдлоо алдсан зэрэг 80 гаруй заалтыг хяналтаас хасах саналыг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем ([www.unelgee.gov.mn](http://www.unelgee.gov.mn))-д оруулав.

2018 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийн хувь доогуур гарсан заалтуудын шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, цаг хугацааны хувьд ач холбогдлоо алдсан заалтуудыг хяналтаас хасуулахаар ЗГХЭГ-т хүргүүлэх, 2018 оны сүүлийн хагас жилд хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, бусад төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх зүйл заалтуудын хэрэгжилтийг гаргах зэрэг арга хэмжээ авч ажилласан.

Гадаад харилцааны яамны чиг үүрэгт хамаарах хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг 2018 оны байдлаар гарган хүснэгтэд харуулав.

№	Эрх зүйн актын нэр	Шийдвэр тоо	Зүйл, заалтын тоо	Биелэлтийн хувь				Үнэлгээгүй / хугацаа болоогүй	Дундаж хувь
				100	70	30	0		
1.	Хууль тогтоомж	3	4	3				1	100
2.	Улсын Их хурлын тогтоол	3	4	3	1				92.5
3.	УИХ-ын байнгын хорооны тогтоол	5	9	5	3			1	88.75
4.	Ерөнхийлөгчийн зарлиг	5	6	4	2				90.0
5.	ҮАБЗ-ийн зөвлөмж	4	4	3	1				92.5
6.	ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл	51	51	25	26				84.70
7.	Засгийн газрын тогтоол	42	60	44	10			6	94.44
8.	Ерөнхий сайдын захирамж	9	9	6	3				90.0
9.	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	99	167	117	39			11	92.5
10.	Засгийн газрын албан даалгавар	1	12	8	4				90.0
<b>Нийт</b>		<b>224</b>	<b>325</b>	218	88			19	<b>91.37</b>

Гадаад харилцааны сайдын зөвлөлийн хуралдаанд гадаад харилцааны салбарт холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2018 оны бүтэн жилийн

хэрэгжилтийг танилцуулж дараах зөвлөмжийг яамны газар, нэгж, ДТГ-уудад хүргүүлэв.

1. Гадаад харилцааны салбарт холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг газар, нэгжүүдийн удирдлагууд улирал бүр хариуцсан ажилтнуудаар гаргуулан хэрэгжилт удааширч байгаа заалтуудад хяналт тавьж хэрэгжилтийг хангаж ажиллах;

2. Газар, нэгжүүд “Хууль тогтоомж, тогтоол шийдвэр”-ийн биелэлт гаргахдаа заалт бүрийн дагуу хийсэн ажлаа товч тодорхой гарган ирүүлж байхын зэрэгцээ шинээр нэмэгдсэн заалтуудын биелэлтийг нарийвчлан гаргахад анхаарч ажиллах;

3. Гадаад харилцааны салбарт холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалтад орсон “Дээд өндөр түвшиний болон Засгийн газрын гишүүдийн айлчлал, Засгийн газар хоорондын комиссын хуралдааны төлөвлөгөөний хэрэгжилтэд байнгын хяналт тавьж бусад төрийн яам, байгууллагуудын хариуцсан заалтуудын биелэлтийг улирал бүр гаргуулан нэгтгэж ХШҮДАГ-т ирүүлж байх.

#### 1.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд гадаад харилцааны чиглэлээр тусгагдсан тус яам болон бусад яамтай хамтран хэрэгжүүлэх нийт 33 зорилтын 94 заалт тусгагдсан. Үүнээс ГХЯ дангаараа 60, бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэгчээр 34 арга хэмжээ тусгагдсан байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээний заалт болон хэрэгжилтийн байдлыг хувиар үзүүлбэл:

<b>Хөтөлбөрийн заалтын хэрэгжилтийн хувиар</b>			
<b>Д/д</b>	<b>100</b>	<b>70</b>	<b>40</b>
1.	2.11.2	2.11.1	
2.	4.2.5.4	2.116.1	
3.	4.4.4.5	5.2.6.1	
4.	5.2.6.2	5.6.3.4	
5.	5.2.6.3	5.6.3.7	
6.	5.6.1.1	5.6.6.5	
7.	5.6.1.3	5.6.6.7	
8.	5.6.1.4	5.6.8.3	
9.	5.6.1.9	5.6.8.4	
10.	5.6.1.11	5.6.8.5	
11.	5.6.1.12	5.6.10.4	
12.	5.6.2.1	5.6.12.2	
13.	5.6.2.3	5.6.12.4	
14.	5.6.3.4		
15.	5.6.3.1		
16.	5.6.3.2		
17.	5.6.3.3		
18.	5.6.3.4		
19.	5.3.3.5		
20.	5.3.3.6		

21.	5.6.4.1			
22.	5.6.4.2			
23.	5.6.4.3			
24.	5.6.5.1			
25.	5.6.6.1			
26.	5.6.6.2			
27.	5.6.6.3			
28.	5.6.6.8			
29.	5.6.7.2			
30.	5.6.7.3			
31.	5.6.7.4			
32.	5.6.7.5			
33.	5.6.7.6			
34.	5.6.8.1			
35.	5.6.9.1			
36.	5.6.9.3			
37.	5.6.9.4			
38.	5.6.10.1			
39.	5.6.10.2			
40.	5.6.11.1			
41.	5.6.11.1			
42.	5.6.11.2			
43.	5.6.11.3			
44.	5.6.12.2			
45.	5.6.12.3			
46.	5.6.12.4			
47.	5.6.13.1			
<b>Нийт</b>	<b>35</b>	<b>23</b>	<b>0</b>	<b>60</b>

Нийт 94 заалтаас

100 хувийн хэрэгжилттэй	47
70 хувийн хэрэгжилттэй	13
40 хувийн хэрэгжилттэй	0
Үнэлэх боломжгүй	34

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний хэрэгжилтийг гаргахдаа ГХЯ-ны гүйцэтгэсэн ажлыг тайлагнаж, хэрэгжилтэд үнэлгээ тавихгүй байхаар заасан тул "үнэлэх боломжгүй" гэсэн 34 заалтыг үндсэн хэрэгжилтийг хариуцагч бусад байгууллага тайлагнах болно.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 2018 оны хагас жилийн байдлаар 75.2 хувьтай гарч байсан бол 2018 оны жилийн эцсийн байдлаар үнэлгээ 18.3 хувиар нэмэгдэж дунджаар 93.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

1.3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд нийт 1 зорилтын 4 ажил, арга хэмжээ тусгагдсанаас 2018 оны байдлаар хэрэгжилтийн дундаж үнэлгээ 85.0 хувь байна.

№	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр	Хэрэгжилтийн хувь
Зорилт 17. Хөрш орнуудад хийх худалдааг өргөжүүлэх бодлого хэрэгжүүлж, хилийн чанадад амьдарч буй монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог сайжруулна						
17.1	Гадаад бодлогын үзэл баримтлал /цаашид “ГБҮБ” гэх/-ын 3.21.6, ЗГҮАХ-ийн 5.6.5, 5.6.7, ЭЗСХ-ийн 2.1.2 дахь заалт	Хөрш орнуудтай хийх худалдааг өргөжүүлэх зорилгоор хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны чөлөөт бүс байгуулах ажлыг эрчимжүүлэх	Замын-Үүд-Эрээний чөлөөт бүс байгуулах ажлын явц, хувиар	50.0	1,466.9 мянган.төг	70
17.2	МУТХҮБ-2030-ын 2.1.7, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 5.6.5, ЭЗСХ-ийн 1.1.6 дахь заалт	Монголын бараа, бүтээгдэхүүнийг таатай нөхцөлөөр экспортлох боломжийг бүрдүүлэх, тарифын болон хязгаарлалтыг бууруулах	Яриа хэлэлцээр хийх орны тоо	3-аас багагүй	702.7 мянган.төг	70
17.3	ГБҮБ-ын 2.14.1, ЗГҮАХ-ийн 5.6.2, ЭЗСХ-ийн 2.1.2 дахь заалт	Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын “Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд Хөрөнгө оруулалтын зураг төслийн төв байгуулах	Төв байгуулах ажлын явц, хувиар	100	-	100
17.4	ГБҮБ-ын 6.27.5, ЗГҮАХ-ийн 5.3.12 дахь заалт	Хилийн чанад байгаа монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдэнд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	Цахим үйлчилгээ ний нэр төрөл, тоогоор	20-иос багагүй	-	100

Тухайлбал, үндсэн чиглэлийн 17.1-д “Хөрш орнуудтай хийх худалдааг өргөжүүлэх зорилгоор хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны чөлөөт бүс байгуулах ажлыг эрчимжүүлэх”, мөн 17.2-т “Монголын бараа, бүтээгдэхүүнийг таатай нөхцөлөөр экспортлох боломжийг бүрдүүлэх, тарифын болон

хязгаарлалтыг бууруулах” гэсэн заалт нь “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70.0 хувь байна.

Үндсэн чиглэлийн 17.3-т Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын “Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд Хөрөнгө оруулалтын зураг төслийн төв байгуулах” гэсэн арга хэмжээ нь 2019 онд ГХЯ-ны төсвийн төсөлд суулгах болсноор хэрэгжилт 100 хувь биелсэн гэж үзэж байна. Мөн 2018 оны хагас жилийн байдлаар 40.0 хувьтай гарч байсан 17.4 дэх заалтын “Хилийн чанад байгаа монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдэнд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах” гэсэн заалт 100.0 хувь биелсэн байна.

Үндсэн чиглэлийн биелэлтийг 2018 оны жилийн эцсийн байдлаар гаргаж ГХЯ-ны 2019 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 13/237 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн болно.

## **Хоёр. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ**

### **2.1. Гадаад харилцааны яамны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт**

ГХЯ-ны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 227 ажил арга, хэмжээ тусгагдсан бөгөөд эдгээр ажил, арга хэмжээний биелэлтэд Засгийн газрын 89 дүгээр тогтоолын хавсралтын 6.2.1-д заасны дагуу үнэлгээ хийхэд 168 ажил, арга хэмжээ 100 хувийн (үр дүнтэй) үнэлгээтэй, 38 ажил 70 хувийн (тодорхой үр дүнд хүрсэн) үнэлгээтэй, 21 ажил, арга хэмжээ “үнэлэх боломжгүй” гэсэн дүнтэй гарав.

Төлөвлөгөөний биелэлтийн хувийг хүснэгтээр дор үзүүлэв.

№	Биелэлтийн дүн /хувиар/	Төлөвлөсөн ажлын тоо
1.	100 хувь (үр дүнтэй)	168 ажил, арга хэмжээ
2.	70 хувь (тодорхой үр дүнд хүрсэн)	38 ажил, арга хэмжээ
3.	40 (эрчимжүүлэх шаардлагатай)	0
4.	0	0
5.	Үнэлэх боломжгүй	21 ажил, арга хэмжээ
<b>Хэрэгжилтийн хувь</b>		<b>94.47 хувь</b>

Яамны үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөний биелэлт дунджаар **94.47** хувьтай байна. /Хавсралт 1/

### **2.2. Гадаад харилцааны яамны хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт**

ГХЯ-ны хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын 2018 оны жилийн төлөвлөгөөний биелэлтийг дээр дурдсан журмын 10 дугаар хавсралтад дурдсан шалгуур үзүүлэлтээр гаргахад нийт үнэлгээний дундаж хувь 100 хувьтай байна.

Гадаад, дотоодын сургалтын талаарх мэдээллийг тухай бүр яамны нийт албан хаагчдад хүргүүлж, сонгон шалгаруулах замаар 2018 онд магистрын сургалтад /1-2 жил/ 3, дипломатын сургалтад /7-45 хоног/ 50, гадаад худалдааны боловсон хүчнийг бэхжүүлэх сургалтад 44, гадаад хэлний сургалтад /2-6 сар/ 4, орчуулагчийн сургалтад 15 давхардсан тоогоор нийт 116 албан хаагчийг хамруулав. Түүнчлэн, ГХЯ-ны нэр дээр ОХУ-ын “Роснефть” компанийн тэтгэлгээр Москвагийн Олон улсын харилцааны их сургууль болон И.М.Губкины нэрэмжит Нефть, хийн их сургуульд суралцах иргэдийн элсэлтийн шалгалтыг Ерөнхийлөгчийн Тамгын газар болон БСШУСЯ-тай хамтран 2018 оны 3 дугаар сард зохион байгуулж, шалгарсан 10 иргэний материалыг ОХУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-аар дамжуулан холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэв.

ТНБД-аар батлуулсан 2018 онд дотоодын сургалтын төлөвлөгөөний дагуу Нийтийн албаны удирдах албан тушаалтнуудад зориулсан авлигын эсрэг сургалт, Жендэр ба хөгжил, Төрийн болон албаны нууцыг хамгаалах хууль тогтоомжийн талаарх сургалт, Монгол Улсын нийгэм, эдийн засаг, гадаад худалдааны өнөөгийн төлөв байдал, ойрын үеийн зорилт, гадаад сурталчилгаа, соёлын харилцааны тухай зэрэг 13 удаагийн сургалтад нийт ажилтнуудыг хамруулав. Үүнээс гадна 2018 онд томилолт авсан дипломат, төрийн захиргааны болон үйлчилгээ техникийн ажилтнуудад зориулж тус яамны Консулын газартай хамтран тусгай сургалтын төлөвлөгөөг ТНБД-аар батлуулж ерөнхий мэдээлэл, үндсэн ойлголтын болон дадлага хийх 21 төрлийн сургалтыг тухайн ажилтнууд, тэдний гэр бүлийн гишүүд болон залуу ажилтнуудыг хамруулж, зохион байгуулав. /Хавсралт-6/

## **Гурав. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ**

### **3.1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ**

Гадаад харилцааны яамны албан ёсны цахим хуудас /mfa.gov.mn/-д 2018 оны турш нийт 788 мэдээ, мэдээлэл тавигдсан байна. Үүнээс үндсэн үйл явдал цэсэнд 608, ДТГ-аас ирсэн мэдээ цэсэнд 151, зарлал цэсэнд 23, ярилцлага цэсэнд 0, видео цэсэнд 6 ярилцлагыг тус тус байршуулжээ.

Түүнчлэн гадаад харилцааны яамны цахим хуудсыг 2018 онд бүрэн шинэчлэн байршуулав.

Гадаадад ажиллаж амьдарч буй иргэдтэй холбоотой буюу консулын харилцаатай холбоотой мэдээлэл яамны цахим хуудасны консулын мэдээлэл цэсээр дамжин консулын цахим хуудсанд байршиж мэдээг байнга шинэчлэн баяжуулж, гадаад улсад амьдарч буй иргэдэд шаардлагатай мэдээ, мэдээллийг түгээж ажиллав.

Ил тод байдлын 2018 оны үнэлгээ дунджаар 100 хувийн хэрэгжилттэй байна.

Байгууллагын ил тод байдлын үнэлгээний тайланг хавсаргав. /Хавсралт-3/

### **3.2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ**

2018 онд “Шилэн дансны тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.2<sup>1</sup> хэсэг, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3.2.3.5<sup>2</sup>, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 8.2<sup>3</sup>-д заасны дагуу хуулийн хэрэгжилт болон мэдээллийг нэгдсэн цахим хуудсанд үнэн зөв, цаг тухайд нь байршуулсан эсэхэд хяналт тавьж, улирал бүр үнэлгээ өгч, зөвлөмж хүргүүлэн эрсдэлийн удирдлагаар ханган ажиллаж байна.

Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу мэдээллийг байршуулсан байдлыг 2018 оны жилийн байдлаар дүгнэхэд Төсвийн ерөнхийлөн захирагчийн 47 байгууллагын дүнгээр “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт **98.49** хувийн гүйцэтгэлтэй, нийт төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа 3 байгууллага, 42 ДТГ, ТӨБ 1, төслийн 1 байгууллага цахим тайланг хуулийн хугацаанд илгээсэн болно.

Тайлангийн хугацаанд нийт 16 төрлийн давхардсан тоогоор 7107 мэдээлэл цахим хуудсанд байршуулахаас 7000 мэдээлэл буюу 98.49 хувь байршуулж, үүнээс хуулийн хугацаанд 5242 буюу 73.7 хувь, хугацаа хоцорч 1758 буюу 24.7 хувь, 107 буюу 1.51 хувь нь мэдээллээ байршуулаагүй байна. Мэдээлэл байршуулаагүй байгаа байдал нь энэ жилийн тухайд нийт ДТГ-уудад санхүүгийн шинэ программыг нэвтрүүлэн ихэнх газрууд нь жилийн эцсийн санхүүгийн тайлан нь хугацаандаа гараагүйтэй холбоотой төдийгүй ялангуяа ихэнх ДТГ-уудад мэргэжлийн ня-бо ажилладаггүйтэй холбоотой байна.

Гадаад харилцааны салбарын хэмжээний холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд 2018 оны байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд **98.49** хувийн биелэлттэй гарч өнгөрсөн онтой харьцуулахад шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 10.79 хувиар өссөн байна.

Мөн шилэн дансны цахим хуудсанд хуулийн хугацаандаа байршуулсан байдал 22.2 хувиар өсөж, хугацаа хоцорч байршуулсан байдал 15.7 хувиар, мэдээлэл байрлуулаагүй байдал 8.0 хувиар тус тус буурсан байна.

Иймд салбарын хэмжээнд “Шилэн дансны тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт **“Хангалттай”** биелсэн байна. /Хавсралт-4/

### 3.3. Шударга байдлын түвшний үнэлгээ

Авилгатай тэмцэх газар нь “Авилгын эсрэг хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасны дагуу “авилгын хэлбэр, цар хүрээ, шалтгааныг 2 жилд нэгээс

---

<sup>1</sup> Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.

<sup>2</sup> шилэн дансны хөтлөлт;

<sup>3</sup> Дотоод аудитын алба нь улирлын нэгдсэн тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа сарын 25-ны дотор хүргүүлнэ



доошгүй удаа судлан авилгын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх"; мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасны дагуу “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” чиг үүргийг тус тус хэрэгжүүлдэг.

Шударга байдлын үнэлгээ (ШБҮ) нь тухайн байгууллагын гадаад шударга байдлын үнэлгээ (үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийн үнэлгээ), дотоод шударга байдлын үнэлгээ (төрийн үйлчилгээг хүргэсэн төрийн албан хаагчдын үнэлгээ), бодлогод оролцогчдын үнэлгээ (шинжээчдийн үнэлгээ) гэсэн гурван дэд үнэлгээнээс бүрдсэн үнэлгээ юм.

Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний 2018 оны тайланд нийт 62 байгууллага (яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ)-аас Гадаад харилцааны яам 5 дугаар байрт 80.2 хувиар /үүнээс нийт 13 яамдын ШБҮ-ээр 1 дүгээр байрт/, гадаад ШБҮ-ээр 3 дугаар байрт 80.2 хувь, дотоод ШБҮ-ээр 3 дугаар байрт 88 хувиар, бодлогод оролцогчийн ШБҮ-ээр 3 дугаар байрт 76.6 хувийн үнэлгээгээр тус тус орсон байна.

#### 3.4. Хэрэглэгчийн үнэлгээ

ГХЯ-наас иргэдэд үзүүлдэг үйлчилгээ, үйл ажиллагаанд хөндлөнгийн байгууллагаар Хэрэглэгчийн үнэлгээ хийлгэхэд ГХЯ-ны хэрэглэгчийн үнэлгээг дараах үзүүлэлтээр дүгнэсэн байна.

Үзүүлэлт	Дундаж оноо	Тайлбар
1. Хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлж буй шат дамжлага, шуурхай, найдвартай байдал	3.92	Судалгаанд оролцогчдоор консулын газрын үйлчилгээтэй холбоотой хүчин зүйлсийг 12 үзүүлэлтийн хүрээнд үнэлүүлсэн. Энэхүү бүлэг үзүүлэлтэд <b>3.92</b> буюу хэрэглэгч сэтгэл ханамж сайтай байгааг харуулж байна.
2. Ажилтан, албан хаагчдын зан харилцаа, мэдлэг ур чадварын талаарх үнэлгээ	4.21	Судалгаанд оролцогчид консулын газрын албан хаагчийн зан харилцаа, хурдан шуурхай байдал, мэдлэг ур чадвар, үүрэгт ажлаа мэдэх байдал, хэрэглэгчдэд зөвлөгөө, зөвлөмж өгөх байдал, асуудалд хандах хандлага зэрэг 5 үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн.
3. Байгууллагын дотоод орчны үнэлгээ	3.90	Консулын газрын дотоод орчны үнэлгээг 8 үзүүлэлтээр үнэлүүлж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг тодорхойлсон.
4. Байгууллагын гадаад орчны үнэлгээ	3.87	Судалгаанд оролцогчдоор байгууллагын гадаад орчныг 3 үзүүлэлтээр үнэлүүлэв.
5. Санал хүсэлт, өргөдөл гомдол хүлээн авах үйл явцад өгч буй үнэлгээ		Консулын газрын ерөнхий үнэлгээнд санал хүсэлт, өргөдөл гомдолд өгч буй хэрэглэгчийн үнэлгээг оруулаагүй болно.

Хэрэглэгчийн үнэлгээний тайланг хавсаргав. /Хавсралт-7/

## Тав. Дүгнэлт

ГХЯ-ны 2018 оны үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг нэгтгэн авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

1	Үзүүлэлт 2	Хувь 3
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	91.52
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	93.5
	3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	85
	4. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	94
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	94.47
	2. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт	100
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	100
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	98.49
	3. Шударга байдлын түвшний үнэлгээ	80.2
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	80
Ерөнхий үнэлгээ		91

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ

Б.БАЯРСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДЭД ЗАХИРАЛ

Л.ЭРДЭНЭДАВАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ГУРАВДУГААР  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ч.СОЛОНГО